

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/2/СТА-ТӨҮГ

| | |
|----------------|---|
| Агуулга | |
| 1 | Аудитын гэрчилгээ.....3 |
| 2 | Аудитын тайлан.....4 |
| 2.1. | Оршил.....4 |
| 2.2. | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....4 |
| 2.3. | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....5 |
| 2.4. | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....5 |
| 2.5. | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....6 |
| 2.6. | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....6 |
| 2.7. | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....7 |
| 2.8. | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....7 |
| 2.8.1 | Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....8 |
| 2.9. | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....8 |
| 2.10. | Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....8 |
| 2.11. | Шилэн дансны мэдээлэл.....8 |
| 2.12. | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....9 |
| 2.13. | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....9 |
| 3 | Менежментийн захидал.....10 |
| | Менежментийн захидал.....11 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан.....12 |
| 4.4.1 | Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....12 |
| 4.2 | Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....12 |
| 4.3 | Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....13 |
| 4.4 | Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НББОУС | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨҮГ | Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/474
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын дарга Б.Отгонбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 25-наас 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 10-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Г.Энхмаа хариуцаж хэрэгжүүлэв.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ нь 2018 оны санхүүгийн тайланг 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 26 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Тус байгууллага нь Төр, засгийн байгууллагад олон улсын стандартын түвшинд хүрсэн хэвлэлийн бүтээгдэхүүний бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор хэвлэлийн үйлчилгээг олон улсын болон өөрийн орны стандартын түвшинд нийцүүлэн үр ашигтай, хямд өртөг зардалтай, дэвшилтэт хэлбэрүүдийг сонгож ажиллах, үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай хэвийн үйл ажиллагаа, ажлын байрны аюулгүй байдлыг найдвартай хангаж ажиллахаар зорилтоо тодорхойлон ажиллажээ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын дүрэмд зааснаар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэвлэлийн бүх төрлийн үйлчилгээг холбогдох шийдвэр, гэрээ, захиалгын дагуу батлагдсан зардал, норм, стандартын дагуу үйлдвэрлэж нийлүүлнэ.
- Төрийн өмчийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг аардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг шууд гүйцэтгэлээ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Даймонд 5.0” програм хангамж ашигладаг байна.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгов.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлан дахь нийт зардлын дүн нь 527,4 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 5,3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 зөвлөмж өглөө.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| № | Шийдэл | Тоо | Дүн | (сая төгрөгөөр) |
|---|---------------|-----|-----|-----------------|
| | | | | Тайлбар |
| 1 | Зөвлөмж өгсөн | 2 | 1.8 | |
| | Дүн | 2 | 1.8 | |

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан тус байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөнд биет тооллого хийгээгүй, аудитын явцад түүвэрт хамруулан шалгаж амжаагүй дээрх асуудлыг 2019 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ нь үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөгөө

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулдаг бөгөөд 2018 оны үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөгөөр 553,5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 539,2 сая төгрөгийн зардал гаргаж ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 553,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, харилцах дансны хүүгийн орлого 3,6 сая төгрөг орсон байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 429,6 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 53,5 сая төгрөг, үйл ажиллагааны бус бусад зардалд 44,3 сая төгрөгийн тус тус зардал гаргаж, нийт 30,1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2018 оны жилийн эцсийн аудит хийгдсэн зорилтот түвшний биелэлт

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны | | | |
|--------------------------------------|---------------------|-------------|-----------|------------|-------|
| | | төлөвлөгөө | гүйцэтгэл | зөрүү | хувь |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Нийт орлого: | 556,858.7 | 553,500.0 | 557,558.9 | 4,058.9 | 100.7 |
| Үүнээс:цэвэр борлуулалт | 553,472.6 | 553,500.0 | 553,937.7 | 437.7 | 100.1 |
| Нийт зардлын дүн | 466,503.8 | 539,199.9 | 527,414.4 | (11,785.5) | 97.8 |
| Үүнээс: удирдлагын зардал | 46,768.5 | 49,940.0 | 53,494.9 | 3,554.9 | 107.1 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал | 90,354.9 | 14,300.1 | 30,144.5 | 15,844.4 | 210.8 |
| Цэвэр ашиг, алдагдал | 81,319.4 | 12,870.1 | 27,130.0 | 14,259.9 | 210.8 |
| Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | 0.83 | 0.97 | 0.94 | (0.3) | 96.9 |

| | | | | | |
|----------------------------|-----------|-----------|-----------|-----------|-------|
| Нийт авлага | 7,236.2 | - | 53,771.3 | 46,535.1 | 743.1 |
| Нийт өр төлбөр | 14,051.6 | - | 10,694.4 | (3,357.2) | 76.1 |
| Үүнээс: Богино хугацаат өр | 14,051.6 | - | 10,694.4 | (3,357.2) | 76.1 |
| Ажиллагсдын тоо | 18.0 | 16.0 | 16.0 | (2.0) | 100.0 |
| Цалингийн сан | 190,115.3 | 189,972.1 | 200,303.6 | 10,188.3 | 105.4 |

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх шаардлагатай мэдээллүүдийг хуульд заасны дагуу хугацаанд нь мэдээлээгүй, эрх бүхий байгууллагаас баталсан 2018 оны үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө, орлого, зардлын гүйцэтгэлийг, зардлын хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааныг 2018 оны 10-р сард 1 удаа бөөнд нь оруулж мэдээлсэн. Хагас жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг дутуу оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардалтай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 0.8 сая төгрөгийг уралдаан тэмцээний зардалд бэлнээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”; 20 дугаар зүйлийн 20.1.4 “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” заалтуудыг тус тус зөрчсөн.

3.1.2 Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгаж байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2.1 Илрүүлэлт:

Худалдан авсан шатахууны үнэ 1,0 сая төгрөгийг түүхий эд материалын дансанд бүртгэсэн, жолоочийн замын хуудас, тооцоо бодсон акт байхгүй, холбогдох зардлын дансанд бичээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалт, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” –ыг тус тус зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайланд зардал зөрүүтэй илэрхийлэгдэх;
Хөрөнгө шамшигдах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгаж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30 -ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2018 оны 1 сарын 1 | 2018 оны 12 сарын 31 |
|---------------|-------------------------------------|--------------------|----------------------|
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 148,089,282.82 | 114,960,805.49 |
| 1.1.2 | Дансны авлага | 304,693,735.60 | 53,771,320.00 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 436,078.81 | 0.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 2,026,070.60 | 0.00 |
| 1.1.6 | Бараа материал | 273,267,050.48 | 62,746,001.03 |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 207,446,242.96 | 231,478,126.52 |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 447,506,135.77 | 447,458,543.13 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 37,400,000.00 | 37,400,000.00 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 484,906,135.77 | 484,858,543.13 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 692,352,378.73 | 716,336,669.65 |
| 2.1.1.3 | Татварын өр | 10,451,755.16 | 1,365,331.41 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 3,599,894.93 | 9,329,029.80 |
| | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 14,051,650.09 | 10,694,361.21 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 14,051,650.09 | 10,694,361.21 |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 47,942,966.07 | 47,942,966.07 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 19,040,957.77 | 19,252,536.77 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 319,150,000.00 | 319,150,000.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 292,166,804.80 | 319,296,805.60 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 678,300,728.64 | 705,642,308.44 |
| 2.4 | ЭР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 692,352,378.73 | 716,336,669.65 |

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---------------------------------------|----------------|----------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 553,472,619.23 | 553,937,691.50 |
| 2 | Борлуулалтын өртөг | 406,784,901.82 | 429,565,394.98 |
| 3 | Нийт ашиг(алдагдал) | 146,687,717.41 | 124,372,296.52 |
| 5 | Хүүгийн орлого | 3,386,450.10 | 3,621,165.25 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 46,768,451.17 | 53,494,956.99 |
| 12 | Бусад зардал | 12,950,796.76 | 44,354,058.98 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 90,354,919.58 | 30,144,445.80 |
| 19 | Орлогын татварын зардал | 9,035,491.96 | 3,014,445.00 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 81,319,427.62 | 27,130,000.80 |

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---------------------------------------|---------------|---|------------------------------|-----------------------|----------------|
| 2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 47,942,966.07 | 19,040,957.77 | 319,150,000.00 | 210,847,377.18 | 596,981,301.02 |
| Залруулсан үлдэгдэл | 47,942,966.07 | 19,040,957.77 | 319,150,000.00 | 210,847,377.18 | 596,981,301.02 |
| Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | | | | 81,319,427.62 | 81,319,427.62 |
| 2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл | 47,942,966.07 | 19,040,957.77 | 319,150,000.00 | 292,166,804.80 | 678,300,728.64 |
| Залруулсан үлдэгдэл | 47,942,966.07 | 19,040,957.77 | 319,150,000.00 | 292,166,804.80 | 678,300,728.64 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 27,130,000.80 | 27,130,000.80 |
| Өмчид гарсан өөрчлөлт | | 211,579.00 | | | 211,579.00 |
| 2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл | 47,942,966.07 | 19,252,536.77 | 319,150,000.00 | 319,296,805.60 | 705,642,308.44 |

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|--|----------------|----------------|
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 609,534,384.00 | 574,074,112.67 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 609,534,384.00 | 574,074,112.67 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 505,284,558.49 | 590,385,755.25 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 159,600,120.22 | 167,087,153.77 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 40,760,467.98 | 46,528,502.12 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 230,503,020.12 | 264,538,646.08 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 56,920,989.22 | 66,218,453.30 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 17,499,960.95 | 46,012,999.98 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 104,249,825.51 | -16,311,642.58 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 3,386,450.10 | 3,621,165.25 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 3,386,450.10 | 3,621,165.25 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 31,145,500.00 | 20,438,000.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 31,145,500.00 | 20,438,000.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -27,759,049.90 | -16,816,834.75 |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 76,490,775.61 | -33,128,477.33 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 108,998,507.21 | 148,089,282.82 |
| 7 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 148,089,282.82 | 114,960,805.49 |

4.7 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|-------------------------------------|---|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит | Аудитын код: |
| 2019.03.11 | | | САГ-2019/2/СТА-ТӨҮГ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨҮГ | | Сая төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний | |
|----------|--|------------|---------------------------------------|--|---------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Уралдаан тэмцээний зардалд анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар кассаас бэлнээр зарцуулсан. | 0.8 | Зөвлөмж өгөх | Ахлах нягтлан бодогч | Д.Нансалгарьд |
| 2 | Худалдан авсан шатахууныг түүхий эд материалын дансаар дамжуулан бүртгэж зарцуулсан, жолоочийн замын хуудас, тооцоо бодсон акт байхгүй дансны бичилт буруу | 1.0 | Зөвлөмж өгөх | Ахлах нягтлан бодогч | Д.Нансалгарьд |
| | Нийт дүн | 1.8 | | | |